



# МОНГОЛ УЛСЫН САРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА – 2009 ОНЫ 6-Р САР



(Тоймыг Монгол, Англи хэл дээр Дэлхийн банкны вэбсайтаас авч болно: <http://www.worldbank.org.mn>)

Эдийн засгийн уналтын нөлөө нь одоогийн байдлаар улс орны эдийн засгийг бүхэлд нь хамраад байна. Хэдийгээр энэхүү уналтын нөлөөллийн хурдац нь хэд хэдэн салбарт буурч байгаа хэдий ч цаашид банкны салбарт томоохон эрсдэл байна.

2009 оны эхний таван сарын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.8 хувиар буурсан боловч 4-р сартай харьцуулахад өссөн байна. Нийт зардал харьцангуй тогтвортой байсан ч засвар үйлчилгээний зардал өссөн байна. Дэлхийн банкны 6-р сарын эдийн засгийн тоймд эрчим хүчний салбарыг жишээ болгон авсан нь энэхүү уналтын үед үндсэн дэд бүтэцийнхээ засвар үйлчилгээг хэвээр хадгалж байхын ач холбогдлыг харуулж байна. Ийнхүү төсвийн алдагдал арван хоёр сарын гулсмал нийлбэрээр 4-р сартай харьцуулахад бага зэрэг өссөн байна.

Дотоодын эдийн засгийн уналтын удаашралтай байдлаас үүдэн импортын хэмжээ үргэлжлэн буурч гадаад худалдааны тэнцэл сайжирч байна. Зэс, алт, түүхий түлшний экспортын хувьд таатай нөхцөл бүрдэж нийт экспортын хэмжээ 4-р сартай харьцуулахад өсөв. Ам.долларын эсрэг төгрөгийн ханш тогтворжиж Монголбанк гадаад валютын нөөцөө нэмсэн байна. Монголбанк болон банкны системийн хэмжээнд гадаад валютын нөөц өнгөрсөн 05-р сарын сүүлчээр 553 сая ам.доллар мөн 648 сая ам.доллар болон тус тус өссөн байна.


Суурь инфляцийн уналтаас үүдэн 5-р сарын байдлаар инфляци өнгөрсөн 4-р сарын 12.6 хувиас 7.4 хувь болтолоо огцом буурсан байдал нь эдийн засгийн уналтыг баталж байна. МБ өөрийн бодлогын хүүгээ бууруулсанаар энэ 06-р сарын дунд үе гэхэд төв банкны долоо хоногийн хүүгийн хэмжээ 12.75 хувиас 11.5 хувьд хүрч буурлаа. Энэ бууралт нь инфляцийн бууралтын хэмжээнээс бага байсан ба бодит дүнгээр бодлогын хүү одоо нэлээд эерэг боллоо.

Арилжааны банкууд дахь нийт хадгаламжийн хэмжээ өссөн ч төгрөгийн хадгаламж буурч, гадаад валютын хадгаламж нэмэгдсэн байна. Үүний нэг шалтгаан нь төгрөгийн хадгаламжийн улирлын өөрчлөлттэй холбоотой юм.

Чанаргүй зээлийн багц болон хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрийн хэмжээ нэмэгдсээр нийт зээлийн 18.1 хувьд хүрээд байна. 4-р сартай харьцуулахад ЧЗБ нь өнгөрсөн 5-р сард 7.5 хувиар өсч нийт зээлийн 11.6 хувь буюу 294 тэрбум төгрөг болсон байна. Хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрийн хэмжээ 4-р сартай харьцуулахад 6.8 хувиар өсч нийт зээлийн 6.5 хувь болох 165 тэрбум төгрөгт хүрсэн байна. ЧЗБ болон хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрийн өсөлт үйлдвэрлэл, барилга угсралт, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт хамгийн ихээр өссөн байна. Ийм үед арилжааны банкууд хувийн салбарынханд зээл олгохоос маш болгоомжилж байгаа бөгөөд харин эрсдэл багатай гэж тооцогдож байгаа төв банкны үнэт цаасийг илүүтэй худалдан авч байна. Шинээр олгосон зээлийн хэмжээ олон салбаруудад буурсан нь ихэвчлэн бөөний болон жижиглэнгийн худалдаа, уул уурхай, барилга угсралт болон үйлдвэрлэлийн салбаруудад хамгийн их буурсан байна.

### Банкууд зээл олгохын оронд төв банкны үнэт цаасыг худалдаж авч байна.


% жилээс жилд харьцуулсан нийт зээл болон МБ-ны үнэт цаас



Эх сурвалж: Тоймноос харна уу

### ЧЗБ болон хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрийн хэмжээ нэмэгдсээр байна.

Тэрбум төгрөг (нийт зээлд эзлэх хувь)



Эх сурвалж: Тоймноос харна уу

Зээл олголт буурсан энэхүү байдал нь үйлдвэрлэлийн салбар дахь хямралыг улам хурцатгаж байна. Ашигт малтмалын үнэ дахин өссөнөөр зөвхөн уул уурхайн салбар ахицтай байна. Ерөнхийдөө хувийн салбарын орлого болон төлсөн татварын хэмжээ их хэмжээгээр буурч байгаа нь хямралын үеийн үр дагавар юм.

Бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоог 2008 оны 5-р сартай харьцуулахад 20.4 хувиар нэмэгдсэн байна. Үүнд бүртгүүлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа мөн ажилд ороход бэлэн байгаа хүмүүсийн тоог оруулвал ажиллах хүчний нийт ажилгүйдлийн хэмжээ нь 9-өөс 12 хувьд хүрэх магадлалтай.